

Эмийн мэргэжилтэнд тохиолдож буй ёс зүйн асуудлыг судалсан дүн

Б.Удвал¹, Б.Мягмарсүрэн¹, С.Мөнхбат¹

¹АШУУИС, Эм зүйн сургууль, Эмнэлзүйн эм зүй, менежментийн тэнхим

Цахим шуудан: Udva5555@gmail.com, Утас: 88074187

Түлхүүр үг:

Нийтийн үйлчилгээтэй
эмийн сан, эмийн жор,
үйлчлүүлэгч

Товч утга:

Үндэслэл: Нийтийн үйлчилгээтэй эмийн сан нь үйлчлүүлэгчид урьдчилан цаг товлох, төлбөр төлөх шаардлагагүйгээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломжийг олгодог байгууллага юм. Сүүлийн жилүүдэд үйлчлүүлэгч төвтэй эм зүйн тусламж үйлчилгээ хөгжиж жор баригчийн үүрэг зөвхөн эм, эмнэлгийн хэрэгслийг хангах, олгохоос гадна эм зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэл рүү өргөжиж байгаа нь тэднийг өдөр тутам ёс зүйн асуудалтай тулгарах нөхцөлийг бүрдүүлж байна. **Зорилго:** Улаанбаатар хотын нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн жор баригч нарт тохиолдож буй ёс зүйн асуудлыг илрүүлэх. **Арга, аргачлал:** Энэхүү судалгааг 2024 оны 03-р сараас 09-р сар хүртэлх хугацаанд Улаанбаатар хотын нийтийн үйлчилгээтэй эмийн санд 3 сараас дээш хугацаанд ажиллаж байгаа, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь хүчинтэй, судалгаанд оролцохыг зөвшөөрсөн 374 жор баригчийг санамсаргүй түүврийн аргаар сонгон хамруулж асуумжийн хуудсаар мэдээллийг цуглуулав. Статистик боловсруулалтад SPSS-25.0 программ ашиглав. **Үр дүн:** Судалгаанд оролцогчдын 339 (90.4%) нь эмэгтэй, 301 (80.48%) нь эм зүйч, 230 (61.5%) нь 30-аас доош насны, 214 (57.2%) нь нийтийн үйлчилгээтэй эмийн санд 5 хүртэлх жил ажилласан байв. Тулгамдаж буй асуудлыг илрүүлэх нээлттэй асуултын хариултуудыг агуулгаар нь эмийн сангийн удирдлага, зохион байгуулалттай холбоотой, мөрдөж ажиллах хууль, дүрэм журамтай холбоотой болон үйлчлүүлэгчтэй харилцах мэргэжлийн харилцаатай холбоотой асуудал гэсэн үндсэн 3 бүлэг, 15 дэд бүлэгт ангилан кодолж давтамжийг тооцоход жороор олгох эмийг жоргүйгээр авахыг шаардах (56.6%), үйлчлүүлэгчийн харилцаа хандлага (27.5%), хүчингүй жороор эм авах (14%) зэрэг нь хамгийн түгээмэл тохиолдож байгааг тогтоов. **Дүгнэлт:** 1. Жор баригч нарын мэргэжлийн үйл ажиллагаандаа зайлшгүй мөрдөж ажиллах ёстой эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийн мэдлэг 56.1%-д нь хангалтгүй байв. 2. Жор баригчдын зарим ёс зүйн тохиолдлуудад хандах хандлага 54.5%-д нь сөрөг, дадал 48.9%-д нь зохисгүй байна. 3. Жор баригчдын хувьд хамгийн түгээмэл тулгарч буй ёс зүйн асуудал нь иргэд жороор олгох эмийг жоргүйгээр олгохыг шаардах (56.6%), үйлчлүүлэгчийн ёс зүйгүй харилцаа (27.5%), хүчингүй жороор эм авахыг хүсэх (14%) зэрэг асуудлууд байна.

Үндэслэл: Эрүүл мэндийн мэргэжилтэн байх нь эм зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн ёс зүйн зарчмуудыг баримтлахыг шаарддаг.¹ Эмийн сангийн орчинд ёс зүйтэй шийдвэр гарган ажиллахын тулд жор баригчид өөрийн бие

даасан байдлаа хадгалж, байгууллагын зорилго, мэргэжлийн стандартын шаардлагыг тэнцвэртэй хангах хэрэгцээтэй тулгардаг. Гэвч энэ үйл явцад ёс зүйн олон төрлийн сорилт, бэрхшээл үүсдэг.² Мөн эмийн нэр төрөл нэмэгдэх, зөвхөн

жороор олгох эмийн зохицуулалт алдагдах, эмийн зах зээл либералчлагдсанаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд идэвхтэй оролцох үйлчлүүлэгчийн тоо олшрох болон эрүүл мэндийн цахим мэдээллийн системийн хэрэглээ нэмэгдэх зэрэг нь ёс зүйн шинэ сорилтуудыг бий болгосоор байна.³ Эм зүйчид эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчийн хувьд үйлчлүүлэгчийн өмнө хууль эрх зүй, ёс зүй, мэргэжлийн хариуцлага хүлээдэг тул эдгээр зарчмуудыг ойлгож, шийдвэр гаргахдаа хэрэглэх нь нэн чухал юм.⁴

Олон улсад нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн эм зүйн мэргэжилтнүүдийн мэргэжлийн ёс зүйн мэдлэг, ёс зүйн асуудалд хандах хандлагыг үнэлсэн судалгаануудад ёс зүйн талаарх мэдлэг, хандлага хангалтгүй байгааг мэдээлсээр байна. Тухайлбал Wudneh (2020) нарын судалгаанд эмийн сангийн мэргэжилтнүүдийн 89.8% нь ёс зүйтэй холбоотой мэдээлэл авсан боловч 37.7% нь үйлчлүүлэгчтэй ёс зүйн асуудлаар ярилцахад ёс зүйн мэдлэг дутмаг байгааг илрүүлж цаашид мэргэжилтнүүдийн ёс зүйн мэдлэгийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатайг дурджээ.⁵

Олон улсад нийтийн үйлчилгээтэй эмийн санд ажиллаж байгаа эм зүйн мэргэжилтнүүдийн анагаах ухааны ёс зүйн мэдлэг, хандлага, түгээмэл тохиолдож буй асуудлыг илрүүлэх судалгаа нэлээдгүй хийгдсэн ч манай улсад энэ чиглэлээр хийсэн судалгааны ажил ховор байгаа нь уг судалгааг хийх үндэслэл боллоо.

Зорилго: Улаанбаатар хотын нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн жор баригчийн мэргэжлийн ёс зүйн талаарх мэдлэг, хандлага, дадлыг үнэлж, түгээмэл тохиолдож буй ёс зүйн асуудлыг илрүүлэх

Зорилт:

1. Жор баригч нарын мэргэжлийн үйл ажиллагаандаа зайлшгүй мөрдөж ажиллах ёс зүйн тулгуур зарчим, ёс зүйн хэм хэмжээний талаарх мэдлэгийг үнэлэх


2. Жор баригч нарын зарим ёс зүйн тохиолдлуудад хандах хандлага, дадлыг тодорхойлох

3. Нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн жор баригч нарт түгээмэл тохиолдож буй ёс зүйн асуудлыг илрүүлэх

Арга, аргачлал: Энэхүү судалгааг аналитик судалгааны нэг агшингийн загварыг ашиглан АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2024 оны 01 сарын 19-ний өдрийн зөвшөөрлийн (2024/3-01) дагуу Улаанбаатар хотын нийтийн үйлчилгээтэй эмийн санд 3 сараас дээш хугацаанд ажиллаж байгаа, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь хүчинтэй, судалгаанд оролцохыг зөвшөөрсөн 374 жор баригчийг санамсаргүй түүврийн аргаар сонгож хамруулав. Судалгааны мэдээллийг 4 бүлэг, хаалттай 39 асуулт бүхий асуумжийн хуудсаар цуглуулав. Асуумжийг эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм болон олон улсад энэ чиглэлээр хийгдсэн судалгаануудын үр дүнд үндэслэн өөрийн орны онцлогт тохируулан боловсруулж, ойлгомжтой, найдвартай байдлыг шалган судалгаанд ашигласан. Судалгааны үр дүнгийн тоон үзүүлэлтийн статистик боловсруулалтад SPSS-25.0 программыг ашиглаж, $P < 0.05$ үед статистик ач холбогдолтой гэж үзэв.

Үр дүн: Судалгаанд нийт 374 жор баригчийг хамруулсан бөгөөд 301 (80.48%) нь эм зүйч, 73 (19.52%) нь эм найруулагч мэргэжилтэй байсан ба оролцогчдын 339 нь (90.4 %) эмэгтэй, 35 (9.4 %) эрэгтэй байв. Насны бүлгээр ангилж үзвэл 30 хүртэлх насны 230 (61.5%), 30-аас дээш насны 144 (38.5%), мэргэжлийн зэргийн хувьд ахлах 29 (7.8%), зөвлөх 5 (0.5%), тэргүүлэх зэрэгтэй 5 (0.5%), зэрэггүй 341 (91.2%) жор баригч хамрагджээ.


Судалгаанд хамрагдсан эм зүйн мэргэжилтнүүдийн мэргэжлийн ёс зүйн сургалтад хамрагдсан байдал болон өөрийнхөө ёс зүйн мэдлэгийг үнэлсэн байдлыг судлан зураг 1-т харуулав.



Зураг 1. Жор баригчдын ёс зүйн сургалтад хамрагдсан байдал болон өөрийн ёс зүйн мэдлэгээ үнэлсэн байдал. А. Жор баригчдын ёс зүйн сургалтад хамрагдсан байдал В. Жор баригч өөрийн ёс зүйн мэдлэгээ үнэлсэн дүн

Судалгаанд хамрагдсан эм зүйн мэргэжилтнүүдийн мэргэжлийн ёс зүйн сургалтад хамрагдсан байдлыг судлахад 307 (82%) нь сургалтад хамрагдсан, 61 (16.3%) нь хамрагдаагүй, 8 (2.1%) нь мэдэхгүй гэж хариулсан байв. Мөн эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн талаарх өөрийн мэдлэгийг 307 (82.1%) нь маш сайн, сайн, 62 (16.6%) нь дунд зэрэг гэж үнэлсэн бөгөөд оролцогчдын нас ($p=0.018$), төгссөн сургууль ($p=0.027$), ажиллаж буй эмийн сангийн зэрэглэл ($p=0.035$), мөн ёс зүйн сургалтад хамрагдсан байдал ($p=0.026$) зэрэгт статистик ач холбогдол бүхий ялгаатай, мэргэжилтэй уялдуулан судлахад ялгаагүй байлаа.

1. Судалгаанд хамрагдагсдын мэдлэгийг үнэлсэн дүн: Мэдлэгийг 2 бүлэг, 7 асуулт, нийт 34 оноогоор үнэлсэн ба судалгаанд хамрагдагсдын мэдлэгийн дундаж оноо, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг судлан Зураг 2-оор үзүүлэв.




Зураг 2. Судалгаанд хамрагдагсдын мэдлэгийн оноо ба өөрийн ёс зүйн мэдлэгээ үнэлсэн байдлыг харьцуулан судалсан дүн.

А. Судалгаанд хамрагдагсдын ёс зүйн мэдлэгийн дундаж оноо В. Судалгаанд хамрагдагсдын мэдлэгийн дундаж оноог өөрийн ёс зүйн мэдлэгээ үнэлсэн байдалтай харьцуулан судалсан дүн[^]Зураг 2-т судалгаанд хамрагдагсдын мэдлэгийн дундаж оноо 13.021 буюу 38.2%-тай байсан ба хамгийн өндөр оноо 20.00 (58.8%), хамгийн бага оноо 3 (8.8%) байв. Мөн мэдлэгийн дундаж оноонд нас ($p=0.226$), хүйс ($p=0.846$), мэргэжил ($p=0.471$), сургууль ($p=0.331$), ажилласан жил ($p=0.278$), мэргэжлийн зэрэг ($p=0.661$), сургалтад хамрагдсан байдал ($p=0.700$) зэрэг ач холбогдол бүхий ялгаагүй байлаа. Харин өөрийн мэдлэгийг үнэлсэн байдалтай ач холбогдол бүхий ялгаатай ($p=0.016$) буюу өөрийн мэдлэгээ маш сайн гэж үнэлсэн жор баригчдын мэдлэгийн дундаж оноо хамгийн өндөр байв.

Бид жор баригч нарын мэргэжлийн ёс зүйн тулгуур зарчим, хэм хэмжээний талаарх мэдлэгийг түвшнийг тогтоохдоо ёс зүйн тулгуур зарчим болон хэм, хэмжээний дундаж оноог (дундаж оноо=2.75) шалгуур үзүүлэлт болгон дунджаас их бол мэдлэг хангалттай, бага бол хангалтгүй гэж үнэлэхэд оролцогчдын 210 (56.1%) нь хангалтгүй, 164 (43.9%) нь хангалттай түвшинд байна. Мөн мэдлэгийн түвшнийг мэргэжил, нас, ажилласан

жил, эмийн сангийн зэрэглэл, мэргэжлийн зэрэг, өдөрт үйлчилгээ үзүүлдэг үйлчлүүлэгчийн тоо болон ёс зүйн сургалтад хамрагдсан байдал зэрэг хувьсагчтай холбон судлахад статистик ач холбогдол бүхий ялгаагүй байлаа.


2. Судалгаанд хамрагдагсдын зарим тохиолдолд хандах хандлага, дадлын түвшнийг үнэлсэн дүн: Судалгаанд оролцсон эмийн мэргэжилтнүүдийн зарим ёс зүйн асуудалд хандах хандлагыг Лейкертийн 5 онооны 9 асуултаар үнэлэв. “Үйлчлүүлэгч жоргүй олгодог эм авахаар ирэхэд тухайн эмийг заавал хэрэглэх шаардлагагүйг ойлгосон ч эмийг олгоно” гэсэн асуултад (Хандлага 1) 25.4% ($n=95$) нь огт санал нийлэхгүй, 55.6% ($n=208$) санал нийлэхгүй гэсэн эерэг хандлага үзүүлсэн бөгөөд үйлчлүүлэгч өөрөө хэрэглэдэггүй эмийн талаар асуувал бүх мэдээллийг өгөх тухай (Хандлага 2) асуултад 88.8% ($n=332$) оролцогч санал нийлнэ гэж сөрөг хандлага үзүүлжээ.(Зураг 3)



Зураг 3. Судалгаанд оролцогчдын хандлагыг судалсан дүн

Бид судалгаанд оролцогчдын хандлагыг судлахад дундаж оноо 3.24 ± 0.43 (64.8%) байсан бөгөөд дунджаас их бол хангалттай, бага бол хангалтгүй гэсэн хоёр түвшинд ангилав. Судалгаанд хамрагдагсдын 54.5% ($n=204$) нь сөрөг хандлагатай, 45.5% ($n=170$) нь эерэг хандлагатай байв. Хандлагыг насны бүлгээр ялган судлахад 25-аас доош насны 15.5% ($n=58$), 26-30 насны 17.1% ($n=64$), 31-39 насны 11.2% ($n=42$) жор баригч дунджаас бага оноо авсан байна. Хандлагын түвшнийг мэргэжил, нийтийн үйлчилгээтэй эмийн санд ажилласан жил, төгссөн сургууль, үйлчлүүлэгчийн тоо, ёс зүйн сургалтад хамрагдсан байдал, мэргэжлийн зэрэг гэсэн хувьсагчидтай холбон судлахад ялгаагүй, харин насны бүлгээс хамаарч статистик ач холбогдол бүхий ($p=0.014$) ялгаатай байлаа.


Бид жор баригчдын эм олгох үндсэн үйл ажиллагааны ёс зүйтэй байдлыг тодруулахаар Лейкертийн 5 онооны 9 асуултыг ашиглан судлав. “Эмийн жоронд бичигдсэн оргинал эм байхгүй үед ижил үйлчилгээтэй женерик эм олгохоор бол үйлчлүүлэгчдэд мэдэгддэг үү?” гэсэн асуултад (Дадал 1) 52.4% ($n=196$) нь тогтмол, 28.1% (105) нь ихэвчлэн, 16.6% ($n=62$) нь заримдаа, 9 (2.4%) нь хааяа, 0.5% (2) нь хэзээ ч үгүй гэж хариулан зохистой дадал үзүүлэв. Харин “Үйлчлүүлэгч хэрэглэж байсан антибиотикоо гэртээ мартсанаа тайлбарлаад эмчилгээгээ үргэлжлүүлэхийн тулд антибиотикийг жоргүйгээр авахыг хүсвэл эмийг олгох уу?” гэсэн асуултад (Дадал5) 17.4% ($n=65$) нь хэзээ ч үгүй, 31.8% ($n=119$) нь хааяа, 39.3% ($n=147$) нь заримдаа, 9.6% ($n=36$) нь ихэвчлэн, 1.9% ($n=7$) нь тогтмол гэж хариулжээ. (Зураг 4)



Зураг 4. Жор баригчдын дадлыг судалсан дүн

Судалгаанд оролцогчдын дадлын түвшнийг судлахад дундаж оноо 3.47 ± 0.47 (69.4%) дундаж оноог шалгуур үзүүлэлт болгон дунджаас их бол зохистой, бага бол зохисгүй гэж бүлэглэв. Нийт оролцогчдын 51.1% ($n=191$) нь зохистой дадалтай, 48.9% ($n=183$) нь зохисгүй дадалтай байна. Эм зүйчдийн 52% ($n=157$), эм найруулагчдын 47% ($n=34$) нь дунджаас дээгүүр оноо авсан бөгөөд мэргэжил, хүйс, нас, нийтийн үйлчилгээтэй эмийн санд ажилласан жил, төгссөн сургууль, үйлчлүүлэгчийн тоо, эмийн сангийн зэрэглэл, мэргэжлийн зэрэг гэсэн хувьсагчидтай холбон судлахад статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдаагүй.

3. Нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн жор баригч нарт түгээмэл тохиолдож буй ёс зүйн асуудлыг судалсан дүн: Бид жор баригч нарт түгээмэл тохиолдож буй ёс зүйн асуудлыг илрүүлэхээр “Хамгийн түгээмэл тохиолддог ёс зүйн асуудлуудыг бичнэ үү” гэсэн нээлттэй асуултыг асуухад нийт 258 (68.9 %) оролцогч нэг болон түүнээс олон тооны ёс зүйн асуудлуудыг (445) бичжээ. Оролцогчдын хариултыг агуулгаар нь эмийн сангийн удирдлага, зохион байгуулалттай холбоотой асуудал, эмийн сангийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллах хууль, журамтай холбоотой асуудал болон үйлчлүүлэгчтэй харилцах мэргэжлийн харилцаатай холбоотой асуудал гэсэн үндсэн 3 бүлэгт ангилав. (Зураг 5)



Зураг 5. Түгээмэл тохиолддог ёс зүйн асуудлуудыг ангилсан байдал, агуулгаар

Эмийн сангийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллах хууль, дүрэм, журамтай холбоотой асуудлуудаас жороор олгох эмийг жоргүйгээр авах (56.6%), хүчингүй жороор эм авах (14%) зэрэг асуудлууд хамгийн олон давтагдсан байлаа. Харин үйлчлүүлэгчтэй харилцах мэргэжлийн харилцаатай холбоотой асуудлуудаас үйлчлүүлэгчийн харилцаа, хандлага (27.5%) болон жор баригчийн зөвлөгөө, мэдээлэлд итгэдэггүй

(12.4%) зэрэг нь хамгийн олон дурдагджээ. Эмийн сангийн үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалттай холбоотой асуудлуудаас эмийн үнэ (12%) болон нөөцтэй холбоотой асуудал (11.2%) ихэнх хувийг эзэлж байгааг тогтоов. Жор баригч нарт түгээмэл тохиолдож буй ёс зүйн асуудлуудын давтамжийг тодорхойлов. (Зураг 6)



Зураг 6. Жор баригчид түгээмэл тохиолддог ёс зүйн асуудлуудыг тодорхойлсон дүн

Хэлцэмж: Судалгаанд оролцсон жор баригчдын 82.1% нь өөрсдийн ёс зүйн мэдлэгийг маш сайн, сайн гэж үнэлсэн бөгөөд ЭМС-ын 2019 оны А/406 тоот тушаалын хавсралт болох “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”-ийн талаар 88.1% нь дундаас дээш мэднэ гэж хариулсан. Гэвч жор баригч нарын мэргэжлийн үйл ажиллагаандаа зайлшгүй мөрдөж ажиллах ёс зүйн тулгуур зарчим, хэм хэмжээний талаарх мэдлэгийг үнэлэхэд 56.2% нь хангалтгүй байна. Энэ нь судлаач С.Болормаа (2015) нар улсын харьяаны байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнийг оролцуулсан судалгааны үр дүнтэй (58%) ойролцоо байна.⁶ Ibrahim (2024) нарын судлаачид Иракын ёс зүйн дүрмийн талаарх эм зүйчдийн мэдлэг, хандлага, дадлыг үнэлсэн судалгаанд 202 эм зүйч оролцсон бөгөөд 59% нь ёс дүрмийн мэдлэгтэй байгаа нь мөн бидний судалгааны үр дүнтэй ойролцоо байна.⁵ Харин Нигер улсын нийтийн үйлчилгээтэй болон эмнэлгийн эмийн сангийн эм зүйчийн ёс зүйн зарчмын мэдлэгийг үнэлсэн Okoro RN (2022) нарын судалгаанд оролцсон эм зүйчдийн 60.1%, Индонез улсын Суракарта хотын 205 эм зүйчийг хамруулсан Denise Pasesa (2024) нарын судалгаанд оролцсон эм зүйчдийн 64% нь ёс зүйн мэдлэг хангалтгүй байгаа нь бидний судалгааны үр дүнгээс өндөр байна.^{7,8} Энэ нь нийтийн үйлчилгээтэй эмийн санд ажиллаж байгаа эм зүйн мэргэжилтнүүдийн мэргэжлийн ёс зүйн мэдлэг хангалтгүй байдал нийтлэг байгааг харуулж байна.

Бид жор баригч нарын зарим ёс зүйн тохиолдлуудад хандах хандлага болон дадлын түвшнийг тус бүрийн дундаж оноог шалгуур үзүүлэлтээр ашиглан тогтооход 45.5% нь эерэг хандлагатай, 51.1% нь зохистой дадалтай байв. Ibrahim (2024) нарын судлаачдын судалгаанд оролцогчдын 42.6% нь хандлага сайн, 56% нь зохистой дадалтай байсан нь бидний судалгааны

үр дүнгээс бага зэрэг ялгаатай байна.⁵

Сүүлийн жилүүдэд үйлчлүүлэгч төвтэй эм зүйн тусламж үйлчилгээ хөгжиж жор баригчийн үүрэг зөвхөн эм, эмнэлгийн хэрэгслийг хангах, олгохоос гадна эм зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэл рүү өргөжиж байгаа нь тэднийг өдөр тутам ёс зүйн асуудалтай тулгарах нөхцөлийг бүрдүүлж байна.^{9,10} Иймд бид жор баригч нарт өдөр тутам түгээмэл тохиолдож байгаа ёс зүйн асуудлыг илрүүлэх зорилгоор “Хамгийн түгээмэл тохиолддог ёс зүйн асуудлуудыг бичнэ үү” гэсэн нээлттэй нэг асуулт асуусан бөгөөд 258 (68.9%) оролцогч хариулсан байв. Jadranka (2017) нарын судлаачид эмийн сангийн үйл ажиллагаанд тохиолдож болох ёс зүйн асуудал, эм зүйчдийн ёс зүйн талаарх ойлголт, хандлагыг тодорхойлох зорилгоор Хорват улсын 300 эмийн сангийн мэргэжилтэнг хамруулсан судалгааг явуулсан бөгөөд ажлын байранд тулгарч буй ёс зүйн асуудлын талаарх нээлттэй асуултад 76 (30.2%) эм зүйч хариулсан нь бидний судалгааны дүнгээс бага байна.²

Дүгнэлт:

1. Жор баригч нарын мэргэжлийн үйл ажиллагаандаа зайлшгүй мөрдөж ажиллах ёстой эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийн мэдлэг 56.1%-д нь хангалтгүй байв.

2. Жор баригчдын зарим ёс зүйн тохиолдлуудад хандах хандлага 54.5%-д нь сөрөг, дадал 48.9%-д нь зохисгүй байна.

3. Жор баригчдын хувьд хамгийн түгээмэл тулгарч буй ёс зүйн асуудал нь иргэд жороор олгох эмийг жоргүйгээр олгохыг шаардах (56.6%), үйлчлүүлэгчийн ёс зүйгүй харилцаа (27.5%), хүчингүй жороор эм авахыг хүсэх (14%) зэрэг асуудлууд байгаа нь тус тус тодорхойлогдлоо.

Талархал: Энэхүү судалгааг хийж гүйцэтгэхэд тусалж дэмжсэн Монголын Эм Зүйн Байгууллагуудын Нэгдсэн “ЭМ” Холбоо ТББ-ын хамт олонд болон судалгаанд оролцсон нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн эм зүйн

мэргэжилтнүүдэд, мөн судалгааны ажлыг цаг зав гарган хэлэлцэж, санал, зөвлөмжийг харамгүй хайрласан Эм зүйн сургуулийн нийт эрдэмтэн багш нартаа талархал илэрхийлье.

Ном зүй:

1. Rasool Esmalipour, Bagher Larijani, Neda Mehrdad, Abbas Ebadi, Pooneh Salari, The ethical challenges in pharmacy practice in community Pharmacies: A qualitative study, Saudi Pharmaceutical Journal, Volume 29, Issue 12, 2021, Pages 1441-1448, ISSN 1319-0164, <https://doi.org/10.1016/j.jsps.2021.11.003>.
2. Jadranka Vukovic. Perceptions and attitudes of community pharmacists toward professional ethics and ethical dilemmas in the workplace. Res Social Adm Pharm 2018 May;14(5):441-450. Doi: 10.1016/j.sapharm.2017.05.010.
3. Gharaibeh L, Al-Azzam SI, Alzoubi KH, Karasneh RA, Abu-Farha R. Knowledge, practices, and patterns of data confidentiality among pharmacists in a developing country. Heliyon. 2022 Mar 15;8(3): e09115. doi:10.1016/j.heliyon.2022. e09115. PMID: 35342831; PMCID: PMC8941157.
4. <https://www.fip.org/activities-priorities>
5. Wudneh Simegn, Berhanemeskel Weldegerima, Alem Endeshaw, Gashaw Sisay, Abdulwase Mohammed, Dawit Wondimsiegn. Assessment of Community Pharmacy Professionals' Attitude and Perception Towards Ethical Issues in Amhara Region, Ethiopi. Dove press. 2 October 2021 Volume 2021:14 Pages 4127-4139 doi:10.2147/RMHP.S328328
6. Ibrahim Albaroodi KA. Pharmacist knowledge, attitude, and practice regarding pharmacy code of practice and ethics in Iraq. J Public Health Res. 2024 Oct 13;13(4):22799036241290271. doi: 10.1177/22799036241290271. PMID: 39403624; PMCID: PMC11472382.
7. Okoro RN, Hedima EW, Abdullateef S, Aguiyi-Ikeanyi CN, Mudenda S. Ethics of Pharmacy Practice: Ethical Principles Knowledge and Perceived Ethical Practices of Community and Hospital Pharmacists in Nigeria. Ind J Pharm Pract [Internet]. 2022 Oct 9;15(4):308–14. Available from: <http://dx.doi.org/10.5530/ijopp.15.4.55>
8. Denise Pasesa, R., & Da'i, M. (2024). Knowledge and Application of Pharmacist Ethical Practices in Surakarta City. Journal La Medihealtico, 5(2), 251-262. <https://doi.org/10.37899/journalmedihealtico.v5i2.1097>
9. Raimundo R, Cavaco A. "I Solemnly Swear": A Comparative Study of Codes of Professional Ethics amongst Pharmacists from Culturally Diverse European Countries. Pharmacy. 2024; 12(5):143, <https://doi.org/10.3390/pharmacy12050143>
10. Ayenew, W., Seid, A.M., Kasahun, A.E. et al. Assessment of community pharmacy professionals' willingness, involvement, beliefs, and barriers to offer health promotion services: a cross-sectional study. BMC Health Serv Res 22, 1539 (2022). <https://doi.org/10.1186/s12913-022-08944-w>

Ethical Issues Encountered by Pharmacy Professionals

Udval B¹, Myagmarsuren B¹, Munkhbat S¹
¹Department of Clinical Pharmacy and Management, School of Pharmacy, MNUMS
Email: Udval5555@gmail.com, Tel: +976 88074187

Keywords:

Community pharmacy,
prescription, customer
interaction

Background: Community pharmacies are accessible healthcare institutions that offer services without the need for appointments or prepayment. In recent years, the scope of pharmacist responsibilities has expanded from merely dispensing medications and medical devices to providing patient-centered pharmaceutical care, health promotion, and disease prevention. As a result, pharmacists are increasingly confronted with ethical challenges in their daily practice.

Aim: To identify the ethical issues faced by pharmacists working in community pharmacies in Ulaanbaatar, Mongolia.

Materials and Methods: A cross-sectional survey was conducted between March and September 2024 among pharmacists working in community pharmacies in Ulaanbaatar. Participants included 374 pharmacists who had been working for at least three months, held valid professional licenses, and voluntarily agreed to participate. A structured questionnaire was used to collect data. Descriptive statistics were analyzed using SPSS version 25.0.

Results: Among the respondents, 339 (90.4%) were female, 301 (80.48%) were pharmacists, and 230 (61.5%) were under 30 years old. Additionally, 214 (57.2%) had worked in a community pharmacy for less than five years. Open-ended responses were coded into three major categories and 15 subcategories: (1) pharmacy management and organization, (2) compliance with laws and regulations, and (3) professional communication with clients. The most frequently reported ethical issues were: Customers demanding prescription-only medications without a valid prescription (56.6%), Negative or inappropriate client behavior (27.5%), Attempts to use expired or invalid prescriptions (14%)

Conclusion: 1. A total of 56.1% of pharmacists demonstrated insufficient knowledge of the Code of Ethics for healthcare professionals, which is essential for their professional practice. 2. Among pharmacists, 54.5% showed a negative attitude, and 48.9% exhibited inappropriate practices when faced with certain ethical situations. 3. The most common ethical challenges faced by pharmacists include: Requests from clients to dispense prescription-only medicines without a valid prescription (56.6%), Unethical or inappropriate behavior from clients (27.5%), Attempts to obtain medicines using invalid prescriptions (14%).

